

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ  
(2016 оны 1 дүгээр улирлын байдлаар)**

Монголбанкны Хяналт шалгалтын газраас 2016 оны 1 дүгээр улиралд хийж гүйцэтгэсэн ажлын ерөнхий мэдээллийг танилцуулж байна.

- Тайлант улиралд 5 банкинд газар дээрх иж бүрэн шалгалтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд шалгалтаар холбогдох журмын дагуу зээлийн ангиллыг хийж, зээлийн эрсдэлийн санг байгуулдаггүй, хуримтлуулж тооцсон хүүг тэнцлийн гадуур гарган бүртгэдэггүй, зээлийн мэдээллийн санд мэдээлэл оруулаагүй эсхүл буруу зөрүүтэй мэдээлэл оруулсан, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг зөрчсөн зэрэг дутагдлууд илэрлээ. Дээрх банкуудаас 3 банкинд хийсэн шалгалтын дүнг Монголбанкны Хяналт Шалгалтын Зөвлөлийн хуралд танилцуулж, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар үүрэг өгч, 2 банкинд хийсэн шалгалтын дүнг газар хэлтсийн захирлуудад танилцуулсан болно.
- Хяналт шалгалтын газраас 13 банкинд газар дээрх хэсэгчилсэн болон иж бүрэн шалгалтаар банкуудын 40 том зээлийг хугацааны болон чанарын үзүүлэлтээр шалгаж, шалгалтын дүнг газар хэлтсийн захирлуудад танилцуулсан болно.
- Зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн 2014-2016 онд хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд батлагдсан “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”, Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчилэн тогтоосон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн А-58 дугаар тушаал, Банкны санхүүгийн тайлан, бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх загвар маягтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А-200 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан болно.
- “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”, “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар банкуудад өгсөн үүрэг даалгавар болон холбогдох бусад хууль, тогтоомжуудын хүрээнд банкуудад зайнаас хяналт тавих ажлыг хэрэгжүүлж, банкуудаас сар бүр ирүүлсэн санхүүгийн тайлан мэдээг хянан шалгаж, тохируулгын гүйлгээ хийх шаардлагатай банкны тэнцэлд гүйлгээг хийж, тайлангийн хариуг сар бүр хүргүүлж ажилласан болно.
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 12 дугаар сард батлагдсан тушаалаар “Банкны салбарын ажилтны ёс зүйн нэгдсэн мэдээллийн сангийн журам”-ыг хүчингүй болгож, Монголбанк болон Монголын банкуудын холбооны хооронд байгуулсан 2016 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 0616/77 дугаар

“Мэдээллийн сан хүлээлгэн өгөх, хүлээн авах гэрээ”-гээр Монголбанкн дахь банкны салбарын ажилтны ёс зүйн нэгдсэн мэдээллийн санг Монголын банкуудын холбоонд шилжүүлсэн болно.

- Банкуудын үйл ажиллагаанд зайнаас тавих хяналтын хүрээнд банкуудын санхүү, төлбөрийн чадварын талаарх санхүүгийн ерөнхий дүгнэлт, мэдээллийг боловсруулж, банкуудаас ирүүлсэн тусгай зөвшөөрөл хүссэн албан бичиг, материалыг хууль, журам, зааврын дагуу шалгаж удирдлагад танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулах, банкинд хийх хяналт шалгалтыг хугацаанд нь чанартай, тогтмол, үр ашигтай хэрэгжүүлэх үүднээс гадаадын хөрөнгө оруулалттай банкуудын судалгаа, Банкны тухай хуулийн 38.2 дугаар заалтын биелэлт, салбар нэгжийн өөрчлөлтийн судалгааг боловсруулж удирдлагуудад танилцуулж шаардлагатай арга хэмжээг авсан болно.

## ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР